



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/76

Хэрлэн сум

Сургалтанд хамруулах,
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалт, Сангийн сайдын 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтанд хамруулсугай.

2. Холбогдох зардлыг нэгдүгээр хавсралтаар, сургалтанд хамрагдах албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хавсралтаар батлагдсан 600,000 /зургаан зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 430

Аймгийн Засаг даргын 2017 оны 02
дугаар сарын 23 өдрийн 776 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Зардлын нэр	Төсөв	Бүгд үнэ /төгрөг/
Сургалтын төлбөр	75,000*8 хүн=600,000	600,000
Нийт		600,000 төгрөг

Аймгийн Засаг даргын 2017 оны 22 дугаар сарын 23 өдрийн 2178 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Сургалтанд хамрагдах албан хаагчдын нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1.	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
2.	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
3.	Л.Бат-Октябрь	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
4.	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
5.	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
6.	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
7.	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
8.	Э.Хишигням	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн